

**Төвд, манж, монгол хэлээр хавсаргасан  
Субашидын нэгэн эхийн тухай**

**М.Баярсайхан** (МУИС)

**Б.Даваасүрэн** (МУИС)

Монгол газар нутагт ихэд дэлгэрэн тархаж, олонтоо орчуулагдахын сацуу монголын уран зохиолд үлэмжхэн нөлөөлсөн зохиолын нэг бол 13 дугаар зууны эхээр Сажа бандида Гунгаажалцаны зохиосон “*Сайтар номлосон эрдэнийн сан*” буюу самгарди товчилсон нэрээр нь *Субашид* хэмээн алдаршуулсан сургаалын зохиол, түүний тайлбарууд билээ. Одоогоор мэдэгдээд буй Субашидын монгол орчуулга хийгээд тайлбар уйгаржин, дөрвөлжин, тод үсгээр хэдэнтээ гарсныг дурдвал, тарнич тойн Сономгара (14-р зууны эх), ойрдын Зая бандида Намхайжамц (1650-1662 оны үес), урадын мэргэн гэгээн Дамбажалсан (18-р зуун), Цахар гэвш Лувсанчүлтэм (1779), буриадын Сумадиратна (19-р зуун) нарын орчуулга байх агаад төвдийн Ринчинбалын зохиосон Субашидын тайлбарыг ойрдын Тарсан. Тайгун Тажон шикү гүүш нар тус тус 17-р зууны үед орчуулж, өөр нэгэн төвд тайлбар “*Сайтар номлосон эрдэнийн сан нэрт шастирын гол судар ба үлгэр тайлбар сэлт*”-ийг багцаалбал 17-р зууны сүүлчээр Чойжамц гэдэг хүн Хотол номын хүрээ нэрт газраа орчуулсан ажгуу. Энэ тайлбарын орчуулгыг хожим Данагийн гэгээн засан шинэчилсэн байна. Мөн Цахар гэвш Лувсанчүлтэм, Номтын Ринчен (Сумадиратна) нар нэмэж зассан тайлбарыг хийжээ.

Энэ удаа бид хараахан олны сонорт хүрч, судлагдаагүй бололтой төвд манж монгол хэлээр хавсаргасан Субашидын талаар номзүйн мэдээлэл, товч танилцуулга төдийг нийтэлж байна.

Эл нэгэн дэвтэр гар бичмэл эдүгээ Улаан-Үд хот дахь Буриадын Шинжлэх Ухааны Төвийн Ном хадгалах газар гагц хувь буй бөгөөд манжаар *sain gisun-i boobai isan sere nomun-i ujui debtelin*, монголоор *sayin ügetü erdeni-yin sang kemegdekü šastir-un terigün debter* хэмээн гарчиглажээ.

- тус дэвтэрт Субашидын эхний 4 бүлгийн 144 бадаг орсон байна. Хэрэв ойролцоо хэмжээгээр дэвтэрлэсэн байж болох юм гэж үзвэл, үлдсэн 5

бүлэг 313 бадгийг дэд дэвтэр төдийгүй гутгаар дэвтэр үйлдэн үргэлжлүүлсэн байх ёстой мэт санагдана.

- нэгэнт цаашхи хэсэг нь одоогоор олдоогүй тул төгсгөлийн үг байдаг эсэх, орчуулан эмхтгэгч болон он цагийн талаар тодорхойгүй байна.
- зохиолыг муутуу цаасыг хамар гарган нугалж товхисон дэвтэрт хар бэхээр бийрээр бичжээ.
- дэвтрийн зүүн гар талын дээд доод хэсэгт имэрсэн муутуу цаасаар үдсэн.
- хуудасны дугаар тавиагүй.
- дэвтрийн хэмжээ 25,6 смx18,3 см, нийт 156 нүүртэй.
- үүнээс эхний 2 нүүр цулгүй нь гадна хавтсыг орлоно.
- 3 дахь нүүрт мөнөөхөн дурдсан гарчигийг манж монгол дарааллаар тус бүр нэг мөр болгон голлуулж хичээнгүй бичгээр бичжээ.
- 4 дэх нүүр буюу дотор хавтасны арын нүүрийн дээхнэ хэсэгт

ᠶᠡᠨᠢᠰᠬᠠᠨᠨᠢᠲᠦᠩᠭᠠᠢᠵᠦᠬᠦᠭᠦᠯᠦᠭᠴᠢ

ey-e-ber engkejiḡülḡcī süm-e

ijishūn niytungya juytehen

惠寧寺

(hui ning si)

хэмээн төвд, монгол, манж, хятадаар бичсэн нь манжийн хаанаас соёрхсон сүмийн нэр болох нь маргаангүй гэж бодож байна.

5-7 дугаар нүүрт номын эхлэл үг,  
8-38 дугаар нүүрт "мэргэдийг онохуй эн тэргүүн зүйл", 30 бадаг,  
39-67 дугаар нүүрт "сайн араныг онохуй нөгөө бүлэг"-ийн 28 бадаг,  
68-111 дүгээр нүүрт "мунхагуудыг онохуй гутгаар бүлэг"-ийн 43 бадаг,  
112-155 дугаар нүүрт "сайн мууг шинжлэх маш ялгалын дөтгөөр бүлэг"-ийн 43 бадгийг тус тус оруулжээ.

Ингэхдээ нүүрийн дээд хэсэгт төвд эхийг нь шар үсгээр бичиж, дор нь манж болон монгол орчуулгын 4, 4 мөрийг хавсаргах маягаар нүүр тутам нэжгээд бадаг эзлүүлсэн байна. Манж монгол үгийг гүймэгхэн бичсэн буй.

Дэвтрийн эцэс буюу дөтгөөр бүлэг төгссөн газар 1,7 см голчтой дугуй хэлбэрийн цэцгэн хээтэй тэмдэг, ланз үсэг бүхий 2x2 см хэмжээтэй дөрвөлжин гарын тэмдэг дарсан байна.

Энэхүү гар бичмэлийн ялангуяа манж орчуулгад дарж зассан, оруулга хийсэн, ойролцоо утгат үгийг зэргэд тавьсан зүйл цөөнгүй тохиолдож буйгаас үзвэл хожмын хуулбар бус, манжаар анх орчуулсан эх болох нь илэрхий. Гурван хэлээр бичсэн, засвар оруулсан зэрэг нь цөм нэг хүний бийрийн бичиг байхыг бодоход орчуулагч манж төвдтэй монгол хүн байсан болов уу.

Монгол орчуулга нь Сономгарагийн үгчилсэн орчуулгыг зарим нэгэн сул үг нэмсэн, хоёр үгийг монгол хэлний найруулга сонсолзүйд нийцүүлэн байры нь сольсон зэргийг эс тооцвол бараг хэвээр нь хуулбарласан атал манж орчуулгад эхийг барилгүйгээр үг нэмж сольсон, утгачлан буулгасан газар нэлээд бөгөөд манж хэлний найруулгад аль болох нийлүүлэхийг эрмэлзсэн байдал харагдаж байна. Шар үсгээр бичсэн төвд эхийн тухайд гэвэл эдүүгээ мэдэгдэж буй бусад эхүүдтэйгээ илт зөрөх зүйл үгүй. Гэвч Л. Лигетийн 1948 онд Будапешт хотноо гэрэл зургийн аргаар хэвлүүлсэн төвд эхтэй харьцуулахад зарим үйл үгийн цагийг буруу тавьсан, зарим үг болон сул үгийг гээж бичсэн авч тухайн мөрийн дор залруулан бичсэнийг үзвэл 2 янзын төвд эх байснаас тийн мөрийн дор засвар хийсэн байж болох талтай юм.

Ер нь манж хэлээрхи утга зохиолын зүйлд төв ёсны сургаалын зохиолыг дан манжаар бичсэнээс гадна хятад, монголыг нэмэж 2 ба 3 хэлээр хавсарган бичсэн байх нь түгээмэл тохиолддог. Тийнхүү нийтэд түгэн дэлгэрсэн ном зохиолыг олон хэлээр хавсарган бичдэг асан манжийн уламжлалд нийцүүлэхдээ урьд нэгэнт төвд монголоор хавсаргасан Сономгарагийн орчуулгыг барьсан нь санамсаргүй хэрэг бус буюу.

Нэгд, гурван хэлээр хавсарган бичсэн; хоёрт, манжаар орчуулсан гагц орчуулга болохын хувьд уг гар бичмэл маш чухаг дурсгал юм. Эцэст хэлэхэд, энэхүү дурсгалыг МУИС-ийн багш, доктор (ph) Б. Даваасүрэнд хүсэлтийнх нь дагуу үзэх бололцоо олгосон Буриадын Шинжлэх Ухааны Төвийн ном хадгалах газрын захирал, түүхийн ухааны доктор, профессор Ц.П. Ванчикова-д талархал илэрхийлэхийн хамт, зохих ёсоор зөвшөөрлийг эрэн цаашид эл гар бичмэлд эх бичгийн судалгаа хийж, нийтийн хүртээл болгохыг зорьж буйгаа тэмдэглэе.

